



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 80

Номгон

Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3а дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1996 онд үйлдвэрлэгдсэн, 2004 онд Монгол улсад орж ирсэн, 2011 онд худалдаж авсан 16-86 БНХ улсын дугаартай Toyota-lexus 450 маркийн, JT6HJ889610137547 арлын дугаартай, суудлын автомашины худалдах доод үнийг үнэлгээний компаниар үнэлүүлэн 5,5 сая төгрөгөөр тогтоосон тул дуудлагаар худалдсугай.

2. Автомашины дуудлага худалдааг холбогдох хууль журмын дагуу 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 11 цагт Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулж орлогыг тус сумын Төрийн сан банкин дахь Бх.Эр ОНЕРөнхий орлого 100030300910 тоот дансанд төвлөрүүлэхийг сумын Засаг дарга /Ц.Төмөрбаатар/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 63 дугаар тогтоолын 1, 4 дэх заалтыг тус тус хүчингүйд тооцсугай.

4. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийхийг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

0117195

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР